



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УСНЫ ГАЗАР

# ОРХОН-ОНГИ ТӨСӨЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖУУД

Усны газрын дарга З.Батбаяр

2024 он





Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал- 2010

Томоохон гол, мөрөнд урсцын тохируулга хийж, бороо, цас, мөсний усыг хуримтлуулж нөөцлөх, усан санг говь, тал хээрийн ууршил ихтэй бүсэд усыг нөөцлөх, дамжуулах далд систем барьж байгуулна.



НОГООН ХӨГЖИЛ

Эх байгаль анхдагч систем

Байгалийн нөөцийн үр өгөөж

Ус үнэт баялаг

Нүүрстөрөгч багатай, хүртээмжтэй ногоон хөгжил

I үе шат (2021-2030):

Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах үе

II үе шат (2031-2040):

Усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх, усны хуримтлалыг нэмэгдүүлж, хүртээмж, хангамжийг сайжруулах үе

III үе шат (2041-2050):

Байгалийн болон зориудаар арвижуулсан нөөцийг хяналттай, зохистой ашиглаж хэвших үе

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

Зургаа. Ногоон хөгжлийн сэргэлт: Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Гадаргын усны хуримтлал бий болгох



Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх



Усны хайгуул судалгаа хийх ажлыг зохион байгуулах, зохицуулах, нөөц батлах





## МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦ, ТОО БҮРТГЭЛ

Нөөцийн төрөл	Усны нөөц, км <sup>3</sup>	Ашиглах боломжит нөөц, км <sup>3</sup>
Гадаргын ус	<b>554</b>	<b>4.96</b>
Нуур	500	
Мөнх цас, мөсөн гол	19.4	
Гол мөрний ус	34.6	4.96
Газрын доорх ус	<b>10.8</b>	<b>5.6</b>
<b>Нийт усны нөөц</b>	<b>564.8</b>	<b>10.56</b>


Орж байгаа хур тунадасны бүх ус гол мөрний усны нөөцийг бий болгодоггүй бөгөөд ууршилт, шүүрэлтээс үлдсэн хэсэг нь гол мөрөн болж гадаргын усны нөөцийг бүрдүүлэн урсцыг бий болгодог. Дэлхийн дунджаар нийт орж байгаа хур тунадасны 39 % нь гадаргын урсцыг бий болгодог бол манай орны хувьд 10% орчим байдаг.

Энэ нь Монгол орны эх газрын эрс тэс уур амьсгал, далайн түвшнээс дээш харьцангуй өндөрлөг, хуурай бүс нутагт оршдог онцлогоос хамаарч байдаг.

Тухайн жилд орсон хур тунадасны хэмжээнээс хамаарч манай орны гол мөрний усны нөөц жил бүр өөр өөр байдаг ба дунджаар 34,6 км<sup>3</sup>/жил байдаг.




## МОНГОЛ ОРНЫ ЖИЛИЙН НИЙЛБЭР ХҮР ТУНАДАС




Улс	Жилийн дундаж
Дэлхийн дундаж	800-1000 мм
Солонгос	1274 мм
Япон	1668 мм
БНХАУ	645 мм
ОХУ	460 мм
<b>Монгол</b>	<b>47-250 мм</b>

Гол мөрний усны нөөцийн 49.0 хувийг (16.9 км<sup>3</sup>) Хойд мөсөн далайн ай сав, 11 хувийг (3.80 км<sup>3</sup>) Номхон далайн ай сав, 40 хувийг (13.9 км<sup>3</sup>) Төв Азийн гадагш урсацгүй ай савын гол, горхины урсац тус тус эзэлнэ.





## ГАДАРГЫН УСНЫ ТОО БҮРТГЭЛ







МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
 ГАЗРЫН  
 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
 УСНЫ ГАЗАР

# МОНГОЛ ОРНЫ УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

сая.м<sup>3</sup>/жил



Ус ашиглалт	2020 он	2021 он	2022 он	2023 он
Унд, ахуй, сая	83.2	84.5	86.3	87.8
Үйлдвэр, ахуй үйлчилгээ, сая	18.6	16.2	42.6	36.50
Хөдөө аж ахуй, сая	353	339.2	338.6	265.8
Эрчим хүч, сая	40.8	41.5	46.2	46.60
Уул уурхай, сая	95.4	113.4	92.5	208.40
Ус ашиглалт жилд, сая.м3/жил	591	594.8	606.2	645.1



## БНАТ

2020

45.1  
тэрбум

2021

48.1  
тэрбум

2022

50.9  
тэрбум

2023

85.6  
тэрбум



# ОЮУТОЛГОЙ ТӨСЛИЙН УС АШИГЛАЛТ




- 3996 ₮ - ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ ҮНЭ

- 959.04 ₮ - 1678.32 ₮ УУЛ, УУРХАЙД АШИГЛАХ УСНЫ ҮНЭ

- 10,832 АЖИЛТАН

- 400-500 МЯН.М<sup>3</sup>/ЖИЛ УНД АХУЙ/ЧӨЛӨӨЛӨГДСӨН





# УС ХЭРЭГЛЭЭ-АШИГЛАЛТ, ХЭТИЙН ТӨЛӨВ



Унд, ахуй



Үйлдвэр, үйлчилгээ




Хөдөө аж ахуй



Эрчим хүч



Уул уурхай






# “ХӨХ МОРЬ” ТӨСӨЛ

Монгол орны гадаргын усны хуримтлал бий болгох, урсцын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх техникийн төсөөллийг 33 байршилд тодорхойлсон.



# “ХӨХ МОРЬ” ТӨСЛИЙН БАЙРШИЛ




“Хөх морь” төслийн хүрээнд Монгол орны томоохон голууд дээр техникийн боломжтой 33 байршлын судалгаа хийсэн. Тухайн 33 байршилд боомт барихад нийт **52 тэрбум.м<sup>3</sup>** хуримтлуулах боломжтой.




МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УСНЫ ГАЗАР

# ХӨХ МОРЬ ТӨСЛИЙН ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙРШИЛ



Монгол орны гадаргын усны хуримтлал бий болгох, урсацын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх техникийн төсөөллийг боловсруулж, нийгэм, эдийн засаг, экологийн хувьд ач холбогдолтой 10 байршлыг сонгосон. Дээрх 10 байршил нь 3,6 тэрбум.м<sup>3</sup> усны нөөцийг бий болгох боломжтой.

## ХЭРЛЭН-ТООНО ХӨНДЛҮҮРИЙН БАЙРЗҮЙН ЗУРАГ




Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Тооно уулын 2400 м урт, 40 м өндөр боомт нь 1.6 тэрбум.м<sup>3</sup> усан сан үүсгэн 6мВт хүчин чадал бүхий усан цахилгаан станцтай байна.

Нуур байгуулагдсаны дараа жилдээ (120 – 130) сая м<sup>3</sup> усыг олон зориулалтаар авч ашиглах боломжтой болно.

УЦС- байгуулснаар жилдээ 30 мянган.тн хүлэмжийн хийг бууруулна.


Сайншандын аж үйлдвэрийн парк хүртэл 235 км урт, 800мм-ын диаметртэй хос зөөлөн ширмэн хоолойтой 2 өргөлтийн насос станцаар өргөж хүргэнэ.

# ОРХОН-ОНГИ ТӨСӨЛ



Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутагт Мөнгөт уулын усан цогцолбор нь 800м урт, 53м өндөр боомт нь 598сая.м<sup>3</sup> усан сан үүсгэн, 2-4МВт хүчин чадал бүхий усан цахилгаан станцтай байна.

Орхон голыг Майхан толгойн хөндлүүрт боомт барьснаар урсац тохируулгын усан сан үүсгэж Онги гол руу шаардлагатай усыг хүргэх боломж бүрдэнэ. Орхон голоос Онги голыг тэтгэсний дараа далд шугам хоолойгоор Улааннуурын урсацыг тэтгэхээс гадна говийн бүсийн аймаг сумдын ус хэрэглээ болон үйлдвэр уурхайн хэрэгцээг хангана. Төслийн ус түгээх шугамын урт нь ойролцоогоор 535 км.



Ажлын зураг: 3.9 тэрбум ₮

Боомт барих хөрөнгө оруулалт: 11 сая \$

Эх үүсвэр: Улсын төсөв, бусад эх үүсвэр



Хугацаа: 2023-2030



Суурь  
ТҮВШИН:

- ТЭЗҮ: - ТЭЗҮ ( 2020 он )
- Зураг төсөл: - Төсөв батлагдаагүй
- Газар: - Шийдвэр гараагүй



Байршил: Өвөрхангай, Дундговь, Өмнөговь




Цагаан бургастайн усан  
цогцолбор  
65 сая.м<sup>3</sup> ус  
хуримтлуулна.




Онгигол-Улааннуур хүртэл  
236 км ус дамжуулах далд  
шугам хоолойг барина.

# ГОВИЙН БҮСИЙН УС ХАНГАМЖИЙН ТӨСЛИЙН БАЙРШИЛ, УС ТҮГЭЭХ ШУГАМЫН ТРАССЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ



# ГАЗРЫН ДООРХ УСААР ХАНГАХ ТӨСӨЛ



Төсөл нь Бор хөөвөр, Долоодын говь, Цагаанцавын газрын доорх уснаас говийн бүсийн үйлдвэр, уурхайнуудад Сайншанд орчимд  $2 \times 200\,000$  м<sup>3</sup> багтаамжтай усан санд цуглуулж 519 км урт, 800мм-ын диаметртай хос хоолойтой 2 өргөлтийн насос станцаар өргөж хүргэнэ.




# ГОВИЙН БҮСИЙН ҮЙЛДВЭР, УУРХАЙН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН УС ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ТРАСС



# ГОВИЙН БҮСИЙН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ



# ГАЗРЫН ДООРХ УСААР ХАНГАХ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



## ТАЙЛБАР:

1. БОР ХӨӨВӨР, ДОЛООДЫН ГДУСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭС ЦОГТЦЭЦИЙ УСАН САН (2X200 000 М<sup>3</sup>) ХҮРТЭЛХ НИЙТ УРТ - 519.0 КМ
2. ЦАГААНЦАВ ГДУСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭС ЦОГТЦЭЦИЙ УСАН САН (2X200 000 М<sup>3</sup>) ХҮРТЭЛХ НИЙТ УРТ - 309.0 КМ


## ТАНИХ ТЭМДЭГ, ХООРОНДЫН ЗАЙ ХЭМЖЭЭ

-  - ГАЗРЫН ДООРХ УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭР
-  - БОР ХӨӨВӨР, ДОЛООДЫН ГДУСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭС-САЙНШАНД УСАН САН - 55.0 КМ
-  - САЙНШАНД УСАН САНГААС - ЗҮҮНБАЯН - 57.0 КМ
-  - ЗҮҮНБАЯНГААС - ЦОГТЦЭЦИЙ - 407.0 КМ
-  - ЦАГААН ЦАВ ГДУСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭС - ЦОГТЦЭЦИЙ- 309.0 КМ
-  - ЦОГТЦЭЦИЙ - ЗҮҮНБАЯН ХҮРТЭЛХ ШИНЭ ТӨМӨР ЗАМ

# ГОВИЙН БҮСИЙН УС ХАНГАМЖИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

## ӨНӨӨДӨР


**НИЙТ УС АШИГЛАЛТ: 24.5 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ**



**19.2**  
САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ  
(608.8 Л/С)

ӨНӨӨДРИЙН БАЙДЛААР МОНГОЛ ОРНЫ ХЭМЖЭЭНД УС АШИГЛАЛТ 24.5 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ БАЙНА. ҮҮНЭЭС УУЛ УУРХАЙД 19.2 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ БУЮУ 608.8 Л/С АШИГЛАЖ БАЙНА.

**Уул уурхай**  
**ГАЗРЫН ДООРХ УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦ: 112.8 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ**




**88.3**  
САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ  
(2,799.9 Л/С)

УУЛ УУРХАЙД ӨНӨӨДРИЙН БАЙДЛААР ГАЗРЫН ДООРХ УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦ 112.8 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ БАЙГААГААС 21.7% ОДООГООР АШИГЛАСАН БАЙНА. ҮҮНЭЭС 78.3% БУЮУ 88.3 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ (2,799.9 Л/С) АШИГЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

**АШИГЛАХ БОЛОМЖИТ ГАЗРЫН ДООРХ УСНЫ ОРД – 20**

## БОГИНО, ДУНД ХУГАЦААНД (2020-2030 ОН)

**АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦ: 88.3 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ**



**Шаардлагатай нөөц**

**15.7**  
САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ  
(499.3 Л/С)

УУЛ УУРХАЙД ГАЗРЫН ДООРХ УСНЫ АШИГЛАГДААГҮЙ 88.3 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ (2,799,9 Л/С) НӨӨЦИЙН 17.8% БУЮУ 15.7 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ (499.3 Л/С) УСААР БОГИНО, ДУНД ХУГАЦААНЫ ЭРЭЛТИЙГ БҮРЭН ХАНГАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

**Үлдэгдэл нөөц**

Эрдэнэс тавантолгой 250 л/с

Тавантолгой ДЦС 40.0 л/с

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр 220 л/с

**НИЙТ 510 л/с**

**АШИГЛАХ БОЛОМЖИТ ОРД:**

- Бор хөөвөр
- Долоод
- Сайн ус
- Цагаан цав зэрэг газрын доорх уснаас хангах боломжтой юм.

## УРТ ХУГАЦААНД (2030-2050 ОН)

**УСНЫ ЭРЭЛТИЙН ТООЦООЛЛООР:**

**2040 ОНД**  
**ХАМГИЙН ИХ ХЭРЭГЛЭЭ**  
УУХУ – 83%  
БУСАД – 17%

**59.1**  
САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ  
(1,874.0 Л/С)

УРТ ХУГАЦААНД УСНЫ ЭРЭЛТИЙН ТООЦООЛЛООР 59.1 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ (1,874.0 Л/С) УС ШААРДАЛАГАТАЙГААС УУЛ, УУРХАЙД 83%, БУСАД САЛБАРТ 17% ШААРДАГДАХААР БАЙНА. ИЙМД ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭС ХАНГАХ БОЛОМЖГҮЙ БОЛЖ БАЙНА.

**ГАДАРГЫН УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦ: 100-120 ХҮРТЭЛ САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ**

ГАДАРГЫН УСААР ГОВИЙН БҮСИЙН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР 100-120 САЯ.М<sup>3</sup>/ЖИЛ УСЫГ АШИГЛАХ БОЛОМЖТОЙ БАЙГАА НЬ УРТ ХУГАЦААНД ШААРДАГДАХ УСНЫ ХЭРЭГЛЭЭГ БҮРЭН ХАНГАХ БОЛОМЖ БҮРДЭЖ БАЙНА.

**ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:**

**ХЭРЛЭН-ТООНО**  
**595.0**  
САЯ. АМ ДОЛЛАР

**ОРХОН-ОНГИ**  
**402.1**  
САЯ. АМ ДОЛЛАР

# ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ



## ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Батлагдсан ТЭЗҮ Говийн бүсийн үйлдвэр, уул уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хэрэгжилтийг хангах
- Хэрлэн-Тооно ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулах
- Орхон-Онги төслийн эдийн засгийн үр ашгийг сайжруулах тооцоо судалгааг нягтлах
- Онги Цагаанбургастайн боомтын төслийг хэрэгжүүлэх
- Хөрөнгө оруулалтын шийдлүүдийг боловсронгуй болгох



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УСНЫ ГАЗАР

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

**УС БОЛ**

ХОРВОО ДЭЛХИЙН  
ХАМГИЙН ЭНГИЙН МӨРТЛӨӨ  
ХАМГИЙН ГАЙХАМШИГТ ЭРДЭС.